

## ГАДААД ДОТООД ОРЧНЫ ХЯНАЛТЫН КАМЕРЫН 20 ... ОНЫ БҮРТГЭЛ

### 1.Хаягийн хэсэг

КОД

Дүүргийн нэр:

Хорооны дугаар:


1. Хорооны Засаг дарга жил бүрийн 12-р сарын 20-ны дотор бүртгэлийг дүүргийн Цагдаагийн хэлтэст цахим хэлбэрээр хүргүүлнэ.
2. Дүүргийн Цагдаагийн хэлтэс нь бүртгэлийг хороо бүрээр нэгтгэж, цахим хэлбэрээр 12-р сарын 25-ны дотор Нийслэлийн Цагдаагийн газарт хүргүүлнэ.
3. Нийслэлийн Цагдаагийн газар нь бүртгэлийг хянаж баталгаажуулан хороо, дүүргийн дүнгээр нэгтгэн УБ хотын ЗАА-нд 12-р сарын 30-ны дотор цахим хэлбэрээр хүргүүлнэ.

### 2.Бүртгэлийн хэсэг

№	Объектийн нэр, байршил	Нийт хяналтын камерийн тоо	Үүнээс санхүүжилтын эх үүсвэрээр					Байнгын ажиллагаатай хяналтын камерийн тоо
			Улсын төсвөөс	Нийслэлийн төсвөөс	Дүүргийн	ААНБ-ын	Төсөл хөтөлбөрийн хүрээнд	
А	Б	1	2	3	4	5	6	7
	Нийт дүн							

**Шаардлагатай тохиолдолд ЭАБ-11 маягтын дагуу нэмэлт хуудас хэрэглэж, нэмэлт хуудас бүрийг заавал дугаарлана.**

Балансын шалгалт: багана 1 = багана (2+3+4+5+6); багана 7 ≤ багана 1

Бүртгэсэн: Албан тушаал: \_\_\_\_\_

Гарын үсэг: \_\_\_\_\_ \

Тамга\тэмдэг

Хянасан: Албан тушаал: \_\_\_\_\_

Гарын үсэг: \_\_\_\_\_ \

## **Гадаад, дотоод орчны хяналтын камерын жилийн бүртгэлийн маягт (ЭАБ-11) - ыг нөхөх заавар**

Энэ бүртгэлийг бүртгэхдээ хорооны ажилтан тухайн жилийн мэдээллийг 12 сарын 15-ны өдрөөр тасалбар болгон объектын нэр, байршил бүрээр бүртгэн, хорооны Засаг дарга мэдээллийг хянаж, үнэн зөв мэдээллийг цахим хэлбэрээр тогтоосон хугацаанд дүүргийн Цагдаагийн хэлтэст, дүүргийн Цагдаагийн хэлтэс бүртгэлийг хороо бүрээр нэгтгэж, цахим хэлбэрээр тогтоосон хугацаанд нийслэлийн Цагдаагийн газарт, нийслэлийн Цагдаагийн газар бүртгэлийг хянаж, баталгаажуулан хороо, дүүргээр нэгтгэн Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд цахим хэлбэрээр тогтоосон хугацаанд ирүүлнэ.

### **1. ХАЯГИЙН ХЭСЭГ**

Дүүргийн нэрийг бүтнээр бичиж, Багануур дүүрэг- **01**, Багахангай дүүрэг- **04**, Баянгол дүүрэг- **07**, Баянзүрх дүүрэг- **10**, Налайх дүүрэг- **13**, Сонгинохайрхан дүүрэг- **16**, Сүхбаатар дүүрэг- **19**, Хан-Уул дүүрэг- **22**, Чингэлтэй дүүрэг- **25** гэсэн кодыг зохих нүдэнд бөглөнө. Хорооны дугаарыг бичиж, кодыг "Хүн ам, өрхийн бүртгэлийн дэвтэр"-ийг нөхөх заавар болон "Хүн ам" мэдээллийн санг байгуулах заавраас харж нөхнө. Монгол Улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн кодыг Нийслэлийн Статистикийн газар (утас - 328787, 327946), дүүргийн Статистикийн хэлтсээс болон [ubstat.mn](http://ubstat.mn) цахим хуудсаас энэ кодыг мэдэх боломжтой.

### **2. БҮРТГЭЛИЙН ХЭСЭГ**

Тухайн хорооны нутаг дэвсгэрийн нийтийн эзэмшлийн гудамж, талбай (цэцэрлэгт хүрээлэн, бичил цэцэрлэг, тоглоомын талбай, явган хүний зам, ил зогсоол, нийтийн тээврийн буудал гэх мэт), аж ахуйн нэгж, байгууллагын (худалдаа, нийтийн хоол, үзвэр үйлчилгээний газар, зах, дэлгүүр, баар, ресторан, шашны сүм, хийд, шатахуун түгээх газар, банк, санхүүгийн байгууллага, АТМ, барьцаалан зээлдүүлэх газар, сургууль, цэцэрлэг гэх мэт) орчим, орон сууцны барилга, орц зэрэг газарт хүн амын аюулгүй байдлыг хангах зорилгоор суурилуулсан хяналтын камерыг хамруулна.

**Б баганад** дээр дурьдсан газруудад байршуулсан хяналтын камерыг суурилуулсан гудамж, талбай, олон нийтийн газар, дэлгүүр, худалдааны төв, орон сууцны байшингийн байршиж буй хаяг, орцны дугаарыг бичнэ. Жишээ нь: "Ноён" дэлгүүрийн барилгын урд, хойд талын дээд буланд, 10-р байрны 4-р орц гэх мэтээр нэрлэнэ.

**1-р баганад** тухайн объектын нийт суурилуулсан хяналтын камерын тоог бичнэ. 1 дүгээр баганын дүн нь 2-оос 6 дугаар баганы нийлбэртэй тэнцүү байна.

**2-6-р баганад** хяналтын камерын тоог дараах санхүүжилтийн эх үүсвэрээр ялгаж бичнэ. Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр суурилуулсан хяналтын камерын тоог багана 2-4-д бичнэ. Аж ахуйн нэгж, байгууллага өөрийн санаачлагаар гадаад, дотоод орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор, өөрсдийн хөрөнгөөр суурилуулсан хяналтын камерын тоог багана 5-т бичнэ. Гадаадын хөрөнгө, буцалтгүй тусламж, төсөл, хөтөлбөрийн хүрээнд суурилуулсан хяналтын камерын тоог 6-д бичнэ.

**7-р баганад** нийт суурилуулсан хяналтын камераас байнгын ажиллагаатай хяналтын камерын тоог бичнэ. 7 дугаар баганы дүн нь 1 дүгээр баганы дүнгээс бага юм уу эсвэл тэнцүү байна.